

МОНГОЛ ДАХЬ ЧИНГИС СУДЛАЛ, УРЬД, ӨДГӨӨ

Э.Лувсанбалдан¹

Чингис судлал нь зөвхөн Чингис хаан, гүүний залгамж, алтан ургийнхны амьдрал, тэмцлийг судласнаар хязгаарлахгүй нэг улс орон дэлхий дахинд сүр хүчээ бүрэн төгс харуулсны шалтгаан, дорно, өрнийн олон үндэстэн дамнасан худалдаа, соёл урлагийг харилцан солилцуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн арга технологийг харилцан нэвтрүүлж, дипломат харилцааны эх суурийг тавьж, мэдээллийн өргөн харилцаа холбооны үүслийг буй болгосон, XXI зуунд монголчуудын сэргэн мандахад их хааныхаа туулсан замын туршлага, өв уламжлалыг судалж, тодруулах өргөн цар хүрээтэй асуудлыг хамарна. Өөрөөр хэлвэл: одон зурхай математик, анагаах ухаан, бичиг, зан үйл, зоос, цаасан мөнгө, морин өртөө, гааль, татвар, хүн амын тооллого, уран барилга, цэргийн урлаг, хууль цааз, төр засаглалын асуудлууд хамаарагдана. Бид энэ удаа зөвхөн Монгол Улс дахь Чингис судлалын урьд, өдгөөгийн зарим асуудлыг хөндөхөөр шийдсэн юм.

Чингис судлалын эхлэл нь Монгол соёлын үнэт өв “Нууц товчоо”-г тэрлүүлж байсан цаг үетэй уялдаатай хэмээн үзэж байна. Нууц товчоо нь Чингис хааны удам судар, монголын нутагт амьдарч байсан олон овог, аймгуудын аж төрх, зөрчил тэмцэл, дайн дажныг бодитойгоор харуулсан түүхийн хосгүй үнэт баримт бичиг мөн. Чухамдаа Монголын нууц товчоо Чингис судлалын эхлэл суурийг тавьсан гэж үзэх магадлалтай.

Монголчууд Чингис судлалд хамааруулан Чингис хааны Дархан Эшиглэгийн хүү Хорхосунын зохиосон “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл” (1266-1273 онд бичсэн), Лу. “Алтан товч (1628-1634 онд), Саган сэцэний “Эрдэнийн эрихэ” (1662 он), “Болор эрихэ”, Инжинашийн “Хөх судар” зэргээс эхлээд Чингисийн хоёр загалын тууж, архины хор гэмийн тухай Чингисийн есөн өрлөгтэй Өнчин хүвгүүний цэцэлсэн шаштир зэрэг үе үеийн мэргэдийн туурвисан түүх шаштир, монгол түмний оюун сэтгэлгээний дээж болсон ардын домог, үлгэр туульс зохиож өнөөгийн бидэнд үлдээжээ. Монгол дахь Чингис судлал нь адармаатай урт замыг туулахдаа магтаал, шүүмжлэлийн туйлшралын аль алинд нь өртсөөр өдгөө бидэнд өртөөлөн ирсэн билээ.

Чингисийг залгамжлагчдын үед монголд дэлгэрсэн шарын шашин Чингисийг судлахаасаа шүтлэгийн объект, буддын шашны онцлог шинжтэй болгон гуйвуулжээ. Тэр ч бүү хэл Чингисийг орон нутгийн чанартай сахиусан бурхан болгон буддын бурхадын тоонд албан ёсоор оруулсан удаатай. Чингис бол мутартаа очир атгасан Очирваань бурханы хувилгаан гэсэн ойлголт Монголчуудын дунд тэр цаг үеэс буй болж, сүшигтнүүд өнөөг хүртэл тэгж сэтгэсээр байгааг 1995 онд бүтээсэн Очирваань бурханы асар том зээгт наамлаас үзэж болно. (Очирваанийн

1. Монгол судлаач

Э.Лувсанбалдан

зургийг үзүүлнэ. №1) Чингис хаанд бурханы удам байгаагүй. Үүнтэй уялдан ХҮИ-ХХ зууны эхэн хүртэл монголчуудын дунд Чингисийг судлах орон зайд түүнийг бурханчлан шүтэх сан. хар. цагаан сүлдний тахилга давуутай хөгжсөн бололтой. Он цаг. зохиогч нь эс мэдэгдэх “Эзний сангийн судар оршвай” хэмээх гар бичмэл тахилганд юу гэж өгүүлсэнийг үзье. “Зуун амт бүрдсэн идээний дээж шим амт төгссөн рашааны далайгаар суут Богд Чингис хаан нөгүүдийг тахимуй. Бадрангуй галын цогцос маш сайтар бадраан Бадрангуй зул бөгөөд зулсаар тахимуй. Зандан гүгэл арц хүж түлсний үнэр ба сангийн их үлэмж үнэрээр тахимуй”² гэсэн байх юм. Чингисийн сүнс, сүлдийг тахиж аргадах нь сайн сайхныг авч ирж, саад түйтгэрийг зайлуулах хүч чадалтай гэж хуврагууд үздэг байжээ. Энэ тухай сангийн сударт юу гэж өгүүлсний заримаас дурдваас:

Хамаг түйтгэр амарлихуйн шидийг өгөн соёрх

Эмгэг ад амарлихуйн шидийг өгөн соёрх

Буруу тэмцэл амарлихуйн шидийг өгөн соёрх

Буян хишиг дэлгэрхуйн шидийг өгөн соёрх ...

Бурхан багшийн шашин лугаа харшлагч дайсныг

Бат очир мэсээр нэвт нэвт мэсэл

Амин голын судсыг тас тас огточ

Очирдарын шашныг арван зүгт дэлгэрүүл ...

гэх мэтээр хүсэл зорилгоо илэрхийлжээ. (Зураг №2)

Их хаандаа зориулсан өөр хоорондоо адил төстэй зохимжилсан гом, жижиг, хэмжээний сан тахилгын иймэрхүү судар хэд хэдэн хувилбар байгаагийн хоёр нь миний хувийн архивт буй бөлгөө. Зохиогч нь эс мэдэгдэх Ордос мэргэн ламын зохиосон “Суут Богд Чингис хааны сангийн тахил үйлдэхийн ёсон хэрэг хүсэл түргэн бүтээгч “цэнгэлийн далай”” хэмээх судар бол өмнө өгүүлсэнээс 3-4 дахин бага юм. (Зураг №3).

Эдгээрийг дүгнэн үзвээс ХИИ-ХХ зууны эхэн хүртлэх хугацаанд Монголчууд Чингис хааны амьдрал, үйл ажиллагаа, аян дайны сургамж, төрөө төвхнүүлж, түмнийхээ төлөө алд биеэ алжаатал зүтгэж байсныг судлахын оронд түүнийг шүтэн бишрэхэд гол анхаарлаа хандуулж байсан нь илт харагдаж байна.

ХХ зуун эхэн үеэс Ч.Бат-Очирын зохиосон “Монгол Улсын эртнээс уламжлан ирсэнийг товчлон тэмдэглэсэн бичиг” (1928), А.Амарын “Монголын товч түүх” (1934), Монголын түүхийн сурах бичгүүдэд Чингис судлалд түрлэг болох хэрэглэгдэхүүн орж байсныг үгүйсгэх аргагүй.

Гэгэл Монгол дахь Чингис хаан судлал 1949 онд анх удаа шүүмжлэлд өртсөн юм. 1949 оны долдугаар сарын 21-нд Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН)-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо (УТТ)-ын 34\64 дүгээр тогтоол “Ардын унших бичгийн тухай” гарсан билээ⁴. Уг тогтоолд тэмдэглэхдээ: Гэгээрлийн яам нь улс төрийн сүрхий алдаатай “Ардын унших бичиг” гэдэг номыг 1948 онд хэвлэлд өгөөд 1949 оны эхээр гаргажээ. Энэхүү номын дотор Монголын феодализмын тухай бичсэн түүхийн хэсэгт: Чингис хаанаас явуулж байсан дээрмийн аян дайнд ангийн чанартай марксист үнэлэлтийг өгөөгүйгээр барахгүй, харин түүний үйл явдлыг магтсан

2. Богд суут Чингис хааны сан оршив. Гар бичмэл.

3. Суут Богд Чингис хааны цэнгэлийн далай хэмээх Ордос мэргэн ламын зохиол. Гар бичмэл.

4. МАХН-ын ТХ-ны тогтоолууд. Хэвлэлийн тухай (1947-1952). УБ. 1953. Тал 29-31.

Э.Лувсанбалдан

ч зүйл байна. Энэ явдал бол манай сэхээтний хоцрогдонгуй зарим хэсгийн дотор үндэсний явцуу үзэл шигдэн оршиж байгаагийн тусгал мөн юм” гээд тогтоохдоо: Улс төрийн сүрхий алдаатай учир “Ардын унших бичиг” гэдэг номыг хураан авч хүчингүй болгож, номыг бичсэн Жамсранжав, редакторласан Хэвлэл утга зохиолыг хянан шалгах газрын ажилтан Бямбаа нарыг эрхэлж байгаа ажлаас нь халж, нэгэн жилийн хугацаагаар намын орлогч болгоод, номыг зохиосны хөлсийг эдгээр нөхдөөс эгүүлэн төлүүлэх. Гэгээрлийн яамны сайд байхдаа алдаа бүхий энэ номыг хэвлэхийг зөвшөөрч баталсан Чойжамцыг донгодож, уг номыг хэвлүүлэхэд бэлтгэх ажлыг шууд эрхэлж байсан урьд ардын Гэгээрлийн яамны сайдын орлогч байсан Дашцэрэнг хатуу донгодожээ. Мөн тогтоолоор сурах ба унших бичиг, ялангуяа олон нийтэд зориулсан бусад утга зохиолыг бичих явдалд сэхээтэн нарын шилдэг хүчнийг оролцуулж байх, сурах бичиг, бусад хэвлэлийн улс төр, үзэл суртлын хэмжээнд онц анхаарал тавихыг холбогдох байгууллагуудад үүрэг болгосон аж.

Нөхцөл байдал иймэрхүү өнгө аястай байхад түүхч, зохиолч Н.Нагаанбуу “Дэлхийн Чингис хаан”⁵ гэсэн өгүүллийг интернетэд тавихдаа 1966 онд хэвлэгдсэн “Монгол Улсын түүх”-нд Чингис бол феодалын язгууртны эрх ашгийн төлөө зүтгэгч, Ази, Европын ард түмэнд цаглашгүй гай гамшиг учруулсан, зүйрлэшгүй харгис догшин цуст яргачин” гэж бичсэнийг их хаандаа хандсан манайхны судалгаа гүехэн хэмээн дүгнэсэнтэй санал нийлэхгүй байгаагаа дурдмаар бодогдоод болохгүйг яах вэ. Өнгөрөгч зууны дөчөөд оноос ерээд оныг хүртлэх хугацаанд Чингис хаанд эерэг хандсан судлаачид бол “Аягатай хоол руугаа шороо цацсантай” адил болох төдийгүй дээлээ нөмөрхөөс буцахгүй цаг байсан шүү дээ.

Төв Хороо “Ардын унших бичиг”-ийн тухай тогтоол гаргачихаад Чингис судлалд цохилт өгөх асуудал дуусгавар болсон гэж үзсэнгүй. Бараг хагас жилийн хугацаанд Чингисийн үетэй холбогдсон түүхийн хэрэглэгдэхүүнд судалгаа хийсээр 1949 оны арван хоёрдугаар сарын 15-ны “Үнэн” сонины 290 (4366) дугаарт “Хэвлэлийн өндөр үзэл суртлын төлөө” гэсэн бүтэн, хагас нүүр өгүүллийг нийтлүүлсэн байдаг. Тэр өгүүлэлд: МАХН-ын Төв Хорооны 1949 оны 34, 64 дүгээр хурлын тогтоолын ач холбогдлыг өндөр үнэлээд н. Жамсранжав зохиож, н.Бямбаагийн редакторлосон “Ардын унших бичиг” гэдэг ном нь үзэл суртлын талаар дорой, түүхийн баримтыг бүдүүлгээр гуйвуулж, хөрөнгөтний харгис үзлийн хороор нэвгэртэл хордсон байна. Уг номын 56 дугаар талд “Чингисийн үе бол Монголын феодализмын цэцэглэлийн үе байлаа. Учир нь тэр үед Монголын соёл, урлагийн хөгжил феодализмын үйлдвэрийн харьцааны туйлд хүртэл хөгжжээ. Энэ бол Чингисийн эрэлхэг чадамгай, төрийн бодлоготон хүн байсны роль юм” гэжээ. Үүнээс үзэхэд Чингисийн империйн үе бол Монголын “Алтан үе” байсан ба тэр нь Чингисийн гавьяа бөгөөд Монголын соёл урлагийн хөгжлийн туйл бол Чингис хааны хар харгислалын үе байсан гэж зохиогч дүгнээд түүхийн баримт бол үүний эсрэг зүйлийг үзүүлэн баталж байгаа бөгөөд Чингис бол Монголын үйлдвэрлэхүй хүчийг хөгжүүлсэн бүс, харин дээрмийн дайнаар сүйтгэж устгасан юм. Тэрчлэн Монголын соёл урлагийн хөгжил Чингисийн үед туйлдаа хүрсэн гэдэг бүдүүлэг дүгнэлттэй, эрүүл ухаант хэн боловч санал нэгдэж чадахгүй нь эргэлзээгүй хэрэг хэмээн зэмлэжээ.

Уг өгүүлэлд цааш бичихдээ: Чингисийн империйн харгис чанарыг бүрхэгдүүлэн түүнийг Монголын түүхийн дэвшилт хөгжлийн үе мэтээр үзүүлэн магтаж феодализмын өмнө бөхөлзөх явдал манай зарим хүмүүст байгаа юм. Ш.Нацагдоржоос “Нууц товчоонд” бичсэн оршил, н. Л.Дүгэрсүрэнгээс бичсэн “Монголын ард түмэн тусгаар тогтнол, эрх чөлөөнийхээ төлөө тэмцсэн нь” гэдэг товхимол зэрэгт Монголын феодализмын харгис ролийг балардуулж, Чингисийн харгис үйл явдлыг түүний давшилт тал, харгис тал гэх мэтээр дүгнэсэн, марксист-ленинист зарчмаас зайлсан, ангийн чанаргүй бүдүүлэг бөгөөд хоёр нүүртэй дүгнэлтүүдээр

5. Н.Наганбуу. Дэлхийн Чингис хаан. Интернет.

Э.Лувсанбалдан

дүүрэн байна. Чингисийн дэвшилт тал нь энэ харгис тал нь тэр гэх зэргээр өөх ч биш, булчирхай ч биш зүйлээр хутган самууруулах явдал бол бүхэнд мэдээжийн Чингисийн харгис үйл явдлыг бүрхэгдүүлж, Чингисийн харгислалыг зөвтгөн цагаатгахыг хичээсэн оролдлого бөгөөд марксист-ленинист бус, ангийн чанаргүй дүгнэлтийг хийж хөрөнгөтний үзэл сурталд арчаагүй хүлэгдсэн явдал гэсэн байна. Ш.Нацагдоржоос Нууц товчооны⁶ оршилд бичсэн зүйлээс уг өгүүлэлд эш татахдаа: “Энэхүү бичигт 13 дугаар зууны үеийн Монголын нийгмийн байдалд түүхийн ёсоор зайлшгүй шаардагдаж байсан төвлөрсөн улс байгуулах эрмэлзэлгээ ба тэр үеийн жижиг феодалын ба феодалын өмнөх жижиг бутархай улсуудыг нэгтгэж Монголын төвлөрсөн улсыг байгуулахын төлөө тэмцсэн асар их тэмцлийг гайхамшиг яруу сайхнаар тусган үзүүлжээ. Ялангуяа эх орныхоо төлөө халуун амь, бүлээн цусаа хайрлахгүй тэмцэж агсан Монгол хүний эрэлхэг баатар чанарыг тусган үзүүлсэн нь бахдаж баршгүй гэвэл болно”⁷ хэмээн тэмдэглээд. Энэ бол хөрөнгөтний үндсээ баримталсан явцуу үзлийн үүднээс XIII зууны үеийн Монголын феодализмын ордны туулийг магтан сайшаахыг оролдсоноор барахгүй, Чингисийн харгис үйл явдлыг түүхийн аргагүй шаардлага гэх буюу Чингисийн дээрэмчдээс бусад ард түмний бүтээлийг эвдэн сүйтгэснийг ард түмний эх оронч баатарлаг үйлс болгон үзүүлэхийг оролдсон хэрэг. Ингэж түүхийн баримтыг бүдүүлгээр гуйвуулсан нь феодализмд алба барьж түүний соёлын өмнө бөхөлзсөн бөгөөд пролетарийн интернационализмаас маш ангид тасарсан зүйл гэсэн байх юм.

Дүгэрсүрэнг шүүмжилсэн эшлэлийг үзвээс Л.Дүгэрсүрэн “Монголын ард түмэн тусгаар тогтнол, эрх чөлөөнийхээ төлөө тэмцсэн нь” гэдэг товхимолдоо “Монгол овгийн хэсгийг нэгтгэн алсад хүчирхэг гүрэн болохын суурь үндсийг тавьсан Хавул хааны үе болох “хүин нь арслантай адил, зориг нь бүргэд мэт хамаг баатрын эзэн тэргүүлэгч Чингис Тэмүүжин, хоорондын зөрцөл тэмцлээс болж, тасарч сарнин доройтсон Монгол үндэс угсаагаа хөөцөлдөж, нэгдсэн хүчирхэг улс болгохоор тэмцэв. Үүний үрээр Дайчууд, Хатхин, Салжуун, Дорвои татар, Найман, Мэргэд, Ойрд, Бүржигны зэрэг 13 аймаг монгол овогтныг нэгтгэсэн ялагдашгүй хүчирхэг улсыг байгуулжээ” гэжээ. (Уг товхимолын 5 дугаар талд) Л.Дүгэрсүрэнгийн энэхүү дүгнэлт нь Чингис хааныг магтан сайшаасан, түүхийн баримтыг бүдүүлгээр гуйвуулан феодализмын өмнө сохроор бөхөлзсөний илрэл хэмээн буруутгажээ.

Ш.Нацагдорж, Л.Дүгэрсүрэн нарын эдгээр дүгнэлтүүдэд марксист-ленинизмын тууштай зарчимт шугамыг баримталсан зүйл өчүүхэн ч үгүй бөгөөд зөвхөн хөрөнгөтний үндсээ баримталсан явцуу үзлийн байраас Монголын феодализмын харгис ролийг цагаатган, түүнийг магтахыг хичээсэн оролдлогоор дүүрэн байна гэж уг өгүүлэлд дүгнэсэн аж.

Ном, хэвлэлийн үзэл суртлын хэмжээг өндөржүүлэх тухай гаргасан энэ өгүүлэлд манай хэвлэлүүдэд монголын феодализмын төлөөлөгчдийг буруугаар үнэлэн, түүнийг хэт сайшаан магтаж, тэдгээрийг монголын ард түмний жолоодогч болгон дэвшүүлэхийг оролдох явдал нэг бус удаа гарч байсныг Х.Пэрэнлэйн “Монголын цэргийн чадвар”, Б.Содномын “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв” гэдэг өгүүлэлүүдээс баримт болгон тэмдэглэсэн нь буй. Энэ бүхэн нь тухайн үед Чингис судлалыг сонирхогч, Монголын түүхч сэхээтнүүдийн урам зоригийг мохоон дарамталж, Монголын их гүрнийг үндэслэн байгуулагчийн түүхэнд эзлэх байр суурь, судалгааны ач холбогдлыг аль болохоор бууруулахыг зорьсон үйлдэл байв.

Чингис судлалыг хязгаарлахад тохиолдсон дараах эрхийн акт нь 1949 оны аравдугаар сарын 27-нд МАХН-ын Төв Хорооны УТГ-ноос “БНМАУ-ын түүх ба утга зохиолын

6. “Үнэн” сонин, 1949 он, №290 (4366)

7. Монголын нууц товчоо, УБ, 1947, Тал 3.

Э.Лувсанбалдан

сургуулиудад зааж байгаа байдлын тухай” гаргасан 56\104 дүгээр тогтоол⁸ юм. Энэхүү тогтоолд тэмдэглэхдээ: Одоохондоо Монголд марксист шинжлэх ухааны үндсэн дээр боловсруулсан монголын түүх, утга зохиолын тогтвортой сурах бичиггүй байна. Үүний улмаас манай орны түүхт явдлуудыг элдвээр, буруу ташаа тайлбарлах явдал гардаг бөгөөд манай сэхээтний зарим хэсэг, монголын түүх, утга зохиолыг хөрөнгөтний национализмын үүднээс шинжлэх ухааны эсрэг хортойгоор тайлбарладаг болов. Энэ нь ялангуяа монголын феодализмын үе ба феодалын зарим төлөөлөгчдийн ролийг ойлгох явдалтай холбогдоно гээд националис төлөв бүхий зарим сэхээтэн, баг тогтвортой сурах бичиг байхгүй, хөрөнгөтний национализмын илрэлтэй тэмцэх тэмцэл сул байгааг ашиглан, зарим хэвлэлүүдэд хорт националист номлолыг номлож байна хэмээн дурджээ. Энд өгүүлж буй феодалын зарим төлөөлөгчид гэдэг нь Чингис хаан, түүний залгамжлагчдийг нэрлэж байгаа бөгөөд түүнийгээ нэлээд хэдэн баримтаар нотолсон байх юм. Тухайлвал: Шинжлэх ухааны хүрээлэнгийн хэвлэл “Шинжлэх ухаан” сэтгүүлд тус хүрээлэнгийн гишүүн Пэрэнлэйн бичсэн “Монголчуудын цэргийн чадвар” гэдэг өгүүлэл (1942 он) нь национализмаар нэвт шингэсэн, түүхт үйл явдлуудад ангич анализыг хийгээгүйгээр үл барам монголын феодализм, түүний зарим төлөөлөгчдийг магтан, Чингис хааны тухай шинжлэх ухаанч бус дүгнэлтийг хийж, Чингис хаан бол бусад улс түмнийг сөнөөн хэрцгийлж, байлдан дагуулагч, монголын ард түмнийг эзэрхэн сөнөөгч байсан атал түүнийг дарлагчид, гадаадын байлдан дагуулагчдын эсрэг тэмцэгч, хөдөлмөрчдийг жолоодогч, эх оронч гэж үзүүлсэн байна. Х.Пэрэнлэй 1949 онд бичсэн “Пушкин монголчуудын байлдан дагуулах довтолгооны тухай” гэдэг өөр нэг өгүүлэлдээ мөн л өнөөх шугамаа ягштал баримгалж, түүхийн баримтыг зөрчин, Чингис хааны төр ба түүний байлдан дагуулах дайныг давшилттай байсан гэж батлан үзүүлж, тэдгээрийг тэр үеийн нийгэм эдийн засгийн нөхцөлөөс шаардагдсан түүхт хэрэгцээ мэтээр үзүүлээд, ард олныг дарлан нухчих зэвсэг болж байсан Чингис хааны төрийн ангийн чанарын тухай зориуд дув дуугүй өнгөрүүлсэн хэмээн буруутгажээ.

Дурдсан сэтгүүлийн 12-13 дугаарт Б.Содином “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв” гэдэг өгүүлэлдээ монголын феодализмын өмнө бялдуучлан худал хэлэхдээ Чингис хааны үед монголын соёл хамгийн дээд хөгжилдөө хүрсэн бөгөөд Чингис хаан үлэмж соёлт суурин улс үндэстнийг довтолсон аян дайн бол монголын ард түмний баатарлаг тэмцэл юм гэх зэргээр ангич бусаар дүгнэн бичсэн байна гэжээ.

УтГ, Монголын феодализмын үеийн анги ба ангийн тэмцлийг бүрхэгдүүлэн тэр үед ард олон нь феодалуудад хатуу ширүүнээр мөлжигдөж байсан гэдэг баримтыг орхигдуулах, тэрчлэн бусдын газар нутгийг эзлэх, хүн ардыг нь хүйс тэмтрэн хядах, соёл боловсролыг нь бүрэлгэн устгахад чиглэгдсэн Чингис хааны түрэмгий дайны шинж чанарын тухай дув дуугүй дарж өнгөрөөх явдал сэхээтний зарим хэсгийн дунд одоо хүртэл үргэлжилсээр байна хэмээгээд Улсын их сургуулийн хэл бичиг, утга зохиолын багш байсан Рэнчин, оюутны өмнө Буддын шашны зохиолуудыг монгол хэлэнд орчуулсан нь монголын соёлын хөгжилтөд асар их нөлөөг үзүүлсэн хэмээсэн мөртлөө шар шажны зохиолууд монголын ард түмний ухамсрыг хордуулахад зориулагдсан харгис мөн чанартай байсныг дув дуугүй өнгөрүүлсэн, мөн сургуулийн багш Лувсанвандан утга зохиолын хөгжилтийг ард түмний нийгэм-эдийн засгийн хөгжлөөс тасархай авч үзэж байсан, нам, улсын Шинэ хүчний дээд сургуулийн багш Цэдэн зэрэг зарим багш феодализмын үе дэх монголын түүхийг хүн амын бүх давхаргуудын тэмцлийн түүх болгон үзүүлдэг нь буруу бөгөөд шинжлэх ухааны эсрэг дүгнэлт юм. Үүнээс үндэслэн багш нарыг бэлтгэх сургуулийн зарим сурагч монголд ангийн тэмцэл зөвхөн 1921 оноос эхэлсэн гэдэг ойлголттой болжээ хэмээн УтГ дүгнэсэн байна.

Монголын түүх, утга зохиолыг сургуулиудад зааж буй тухай тогтоолоор МУИС-ийн

8. Сургуулийн тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолууд. УБ. 1953.

Э.Лувсанбалдан

Монголын түүхийн хичээлийн хөтөлбөрийн гуравны хоёр хувь. Намын шинэ хүчний дээд сургуулийн дөрөвний гурван хувь нь Монголын феодализмын түүх судлахад зориулагдаж байсныг өөрчилж, сургалтын цагийн тэн хагасаас доошгүй хувийг Ардын хувьсгалаас хойших үед зориулах чиглэл өгөв. Энэхүү тогтоол гарснаас хойш бараг бүтэн улирал өнгөрсний дараа 1950 оны “Үнэн” сонины 2 (4382) дугаарт⁹ “Түүхэн баримтыг гуйвуулах, үндэсний үзлээр тайлбарлах явдалтай эрс тэмцье” хэмээх дэлгэрэнгүй өгүүлэлийг Н.Жамбалсүрэн нийтлүүлжээ. Тэр өгүүлэлд уг тогтоолд тэмдэглэсэнчлэн Ш.Нацагдорж, Л.Дүгэрсүрэн нар дэлхийн монгол судлал, Чингис хаан судлалын ноён оргил болсон “Монголын Нууц товчоо” Чингис хаан, түүний байгуулсан Их Монгол Улс, монголын эзэнт гүрний түүх, хүн нийгмийн түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүрэг, дэлхийн соёл иргэншлийн хөгжилд нүүдэлчдийн байгуулсан маргашгүй гавьяа, хувь нэмэр, ач холбогдлыг бодитой үнэлснийг буруутгаж, Х.Пэрэнлэйн “Монголчуудын цэргийн чадвар” (1942) болон Монголын зохиолчдын эвлэлийн Ерөнхий хорооны хэвлэл “А.С.Пушкин” гэдэг номд бичсэн “Пушкин Монголчуудын байлдан дагууллын тухай” өгүүлэлүүдэд дүн шинжилгээ хийж, Монголын “Феодалын эзэнт улсын байгуулал, бусдын газар нутгийг түрэмгийлэн эзэлж харгислаж байсан Чингис хаан” тэргүүтнийг ангийн тэмцлийн үүднээс үзэлгүй “Аугаа их эх оронч” гэх зэргээр өргөмжлөн магтсан гэх мэтээр Х.Пэрэнлэйг шүүмжлэхэд өгүүллийнхээ зонхилох хэсгийг зориулсан байна. XX зууны монголын ууган том эрдэмтэдийг ийнхүү элдэвчлэн мөшгиж байв. Гэсэн ч Монголын Чингис судлалын хөгжилд тэдний оруулсан хувь нэмрийг бид мартаж учиргүй, өндрөөр үнэлэх учиртай.

Өнгөрөгч зууны дөчөөд оны сүүлч, гавиад оны эхээр БНМАУ-ын тогтмол хэвлэлүүдэд Чингис хаан, эзлэн дарлагдсан орны ард түмнийг цустай нь хатааж байсан тухай шүүмжлэлийг өрнүүлснээс Чингис судлал зогсонг байдалд орсон юм. Сургуулиудын сургалтын хөтөлбөрт Чингис хаан болон түүний залгамжлагчдын үеийг судлах цагийг хэт хомсотгосоноос монголын эзэнт гүрний түүхийн зарим асуудлыг манай хойч үеийнхэн Зөвлөлтийн түүхийн ном зохиолоос дам суралцаж боллоо. ЗХУ-ын Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгээс Дунд сургуулийн VIII ангид үзэх “СССР-ийн түүх” сурах бичгийн хоёр дахь удаагийн хэвлэлд¹⁰ (Номын зураг №3) Зөвлөлтийн профессорууд XIII зууны эхэн үеийн Монголын нийгмийн байгуулал, Чингис хааны эзэнт гүрний үүсэл, хөгжил “Чингисийн арми нь зохион байгуулалтын хувьд онцгой сайн”¹¹ байсныг зөвшөөрөн хүлээж магтан бичдэг байв. Их, дээд сургуулиудын сурах бичгүүдэд Чингис хааны үйл явдлыг бүр дэлгэрэнгүй тайлбарласныг Монгол оюутнууд багш нараас сонсож, баримт бичгээс үздэг байсан юм. Хэдий гийм боловч Чингис судлалыг хөндөгсөд “Үндсэрхэг үзэлтэн” хэмээн ад шоо үзэгддэг байв.

Жараад оны эхэнд Чингистэй холбогдсон нэгэн чухал явдал боллоо. Энэ нь 1964 онд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ой тохиосон явдал юм. 1962 оны эхээр МАХН-ын Төв Хорооны УтТ-ын гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Төмөр-Очир, Чойбалсан аймгийн Намын Бага хурлын индэр дээрээс нэг хүнийг тахин шүтэхийн хор холбогдлыг тайлбарлахын зэрэгцээ Чингис хааны төрсний 800 жилийн ойг Хятад, Япон зэрэг харь орнууд энэ онд тэмдэглэхээр бэлтгэж байгаа тул их хааныг төрүүлсэн манай улс энэхүү ойг тэмдэглэхээр Намын Төв Хороо бэлтгэж байгаа хэмээн онцлон тэмдэглэснийг чих тавин сонссон гэрч нь би болно. Төмөр-Очир тэр үеэр намын Төв Хорооны хоёр тогтоолын төслийг нэмж, хасах зүйл байвал саналаа бич хэмээн надад (Би тэр үед Чойбалсан аймгийн намын хорооны нарийн бичгийн даргын албыг хашиж байсан) өгсөн юм. Түүний нэг нь “Үнэн” сонины аймаг дахь сурвалжлагчийн ажлын тухай, удаах нь “Чингисийн төрсний 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” байлаа.

9. “Үнэн” сонин. 1950. №2 (4382).

10. СССР-ийн түүх. Дунд сургуулийн 8-р ангийн сурах бичиг. УБ. 1953. Тал 78.

11. Чингис хаан монголчуудын үндэсний бахархал, сүр сүлд. УБ. 2002.

Э.Лувсанбалдан

1949 оноос хойш Чингисийн нэрийг хэлсэн хүн буруутгадаг байснаа гэнэт ой тэмдэглэхээр УтТ-ы тогтоол гаргаж, төлөвлөгөө батлах болсонд би бээр Чингис хаанаа харниханд олзлуулахгүй болсон нь яамай даа хэмээн амихандаа баярлаж талархаж байв. Хавсралт төлөвлөгөөнд Чингисийн мэндэлсний 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний Бага хурал хийх, Чингисийн амьдралыг харуулсан марк гаргах, Хэнтий аймгийн Дадал сумын нутаг Гурваннуурын рашаан сувилалыг түшиглэн түүний дунд нуурын хойт хөвөөнд Чингис, түүний есөн өрлөгийн хөшөө босгох, хоёр талын нуурын дунд Чингисийн хоёр загал морийг байрлуулах томхон цогцолбор буй болгохоор төлөвлөсөн нь бүрч сонирхолтой санагдав. Миний бие тогтоол, төлөвлөгөөний төсөлтэй танилцаад “нэмж хасах зүйл надад алга. Сайхан л арг хэмжээ байна” гээд Төмөр-Очир даргад өгсөнд, чи танилцсан тухай гарын үсгээ зур гэдэг юм байна. Би ер санаанд орсон юмгүй гарын үсгээ зураад өгчихлөө. Би тэр жил Москвад ЗХУ-ын Коммунист намын Төв Хорооны дэргэдэх Намын дээд сургуульд суралцахаар яваад 1964 онд төгсгөөд ирсний дараа томилолт авахаар МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарганырын зөвлөлгөөнд орсонд Төмөр-Очирын хамт Чингисийн 800 жилийн ойг тэмдэглэхэд идэвхитэй оролцогч гэсэн хэрэг мандлаа. Цэдэнбал дарга амралтад явснаас Ц.Дүгэрсүрэн хурлыг удирдсан бөгөөд тэрээр надад дөрвөн зүйлийн ярвигтай асуудал тулгав. Үүнд:

- а Чингисийн ойг тэмдэглэх тухай тогтоол, төлөвлөгөөг зөвшөөрч гарын үсгээ зурсан;
- б Чингисийн хөшөө босгох газрыг Төмөр-Очирын хамт үзэж тусалцсан;
- в Хөшөө босгоход ачааны машин өгч тусалсан;

г. Дорнод аймгийн Булган сумын нутагт оршиж байсан Чингисийн Тугийн сүмийн суурийг хэмжиж Төмөр-Очирт ирүүлсэн гэдэг юм байна. Үүний а, г-д заасан нь үндэстэй бөгөөд хөшөөний газар үзэлцсэн, машинаар тусалсан гэдэг нь үндэсгүй болохыг би бээр уг хурал дээр өчиж билээ. Харамсалтай нь Чингисийн цогцолбор төлөвлөснөөр бүтээгүй бөгөөд нэгэн үе Чингис, түүний судлалтай нэр холбогдогч ийм л дарамттай учирч байсныг нотлоход түүний зах сэжүүрээс амсаж явсан миший бие өөрт тохиолдсон үйл явдлаас тодотгохыг чармайж та бүхэнд сонордуулав. Энэ нь манай умарт хөршийн гадаад бодлого, тэдний заалт чиглэлээр ажил хэргээ удирдаг манай тэр үеийн нөхцөл байдлаас болсон хэрэг.

1990 онд улс төрийн өөрчлөлт шинэчлэл өрнөхөд Чингис судал сэргэв. 1990 оны дөрөвдүгээр сард Монголын нууц товчооны 750 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан олон улсын хурал Улаанбаатарт болсон нь хэрэг дээрээ нууц товчооны гол баатар Чингис хааныг цагаатасан, түүний хүндэтгэлд зориулсан нэгэн том арга хэмжээ байв. Ойг тохиолдуулан гаргасан номын үзэсгээнд Монгол Улсаас гадна БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орон, Буриад, Халимагийн Автономит Социалист Бүгд Найрамдах улсын төлөөлөл оролцов. Тэр үеэс Чингис хааны үйл хэргийн хүрээнд бичсэн нийтлэл тогтмол ба тогтмол бус хэвлэлүүдэд ар араасаа зай завсаргүй цувран гарч эхлэв. 1991 онд Чингис хааны томоохон намтарыг дөч, тавиад онд Чингисээс болж сонин хэвлэлээр зад шүүмжлүүлж байсан Ш.Нацагдорж (Академич) бэлтгэн хэвлүүлжээ. Удалгүй Монголд “Чингис судлалын төв” хэмээх төрийн бус байгууллага байгуулагдаж байсан удаатай (Одоохондоо энэ байгууллага тодорхойгүй). Тэр цагаас хойш Чингис хааны нэр орон даяар түгэв.

Шинэ нөхцөлд зөвхөн миний мэдэх Чингис судлалтай холбоотой С.Батсайханы уран дүрийн онолын лекцүүд (1998), Г.Билгүүдэйн Аман уламжлал ба Монголын нууц товчоо (2000), С.Дулмын Чингис хаан төрийн бэлэгдэл (2006), Б.Сумъяабаатарын Чингисийн алтан ургийн угийн бичиг ба гэрийн үеийн бичмэл (2002), Н.Хавхын эзэн Чингис хаан, хүн төрөлхтний

Э.Лувсанбалдан

түүхэнд гүйцэтгэсэн үүрэг (2004), Б.Хишигсүхийн Хөх сударын хоёр эхийн утга, уран сайхны харьцуулсан судалгаа (2005, 2008) Д.Цэвээндоржийн Монгол уран зохиол дахь Чингис хааны дүрийн судалгаа (2007), Д.Цэрэнсодномын "Монголын нууц товчоо (2000) зэрэг судалгааны бүтээл, Рашид Ад Данийн судрын чуулган (2002)-наас эхлээд Ч.Айтматовын Чингис хааны цагаан үүл (2002) зэрэг орчуулгын арваад бүтээл, олон тооны нийтлэл, өгүүлэл, уран зохиол, шүлэг, дууль, кино, дуурийн цомнолууд гарч олны хүртээл боллоо.

Чингис судлал Монголд хөгжиж 2002 онд Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг ШУА, Түүхийн хүрээлэнгээс зохион байгууллаа. 2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Олон Улсын Монгол судлалын холбооноос Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан Олон Улсын монголч эрдэмтдийн IX их хурлыг зарлан хуралдуулсанд дэлхийн 26 орныг төлөөлсөн 400 гаруй эрдэмтэд илтгэлээ хэлэлцүүлээ.

Өдгөө Монгол эрдэмтэд дэлхийн эрдэмтэдтэй хүч хавсран Чингис судлалыг хөгжүүлэх нь шаардагдаж байна. Академич Ч.Далайн тооцсоноор дэлхийн 60 гаруй оронд Чингисийн тухай 500 гаруй ном зохиол, өгүүлэл хэрэглэгдэхүүн хэвлэгдсэн¹² гэдэг.

Э.Лувсанбалдан
САНАЛ ДҮГНЭЛТ

Өмнө өгүүлснийг нэгтгэн дүгнэвээс Чингис судлал хэмээх ухагдахуун, Монголд түүнийг судалсан эхлэлийг хөндөж, Буддын шашны зүгээс Их хааныг хэрхэн үзэж байсан, өмнөх бүтээлүүдэд дэлхийн хүчирхэг эзэн хаадын манлай болсон Чингис хааныг дан ганц сөргөөр авч үзсэн МАХН-ын Төв Хорооны “Ардын унших бичгийн тухай”, “БНМАУ-ын түүх утга зохиолыг сургуулиудад зааж байгаа байдлын тухай тогтоол”-уудыг зөвхөн нэр дурдаад өнгөрдөг байсан бол энэ удаа уг тогтоолуудын агуулга, мөн чанар, сурталчилгааг нөхөн бүрдүүлэх, Чингис судлал манай оронд үзэл бодлын ялгаанаас шалтгаалан сэргэж, унаж байсан зарим баримтыг өөрийн туулсан замналаар баталгаажуулахыг хичээсэнд оршино.

Монгол дахь Чингис судлал хэдэн зууны тэртээгээс эхэлсэн боловч нийгмийн хөгжлийн янз бүрийн үе шатанд хүний ертөнцөөс ангид “Бурханчлан” шүтэгдэж байснаа цагийн өнгөнд зохицсон түүхчдийн үед “Буг” болон шүүмжлүүлж, Чингис судлал жинхэнэ утгаараа хөгжих боломжтой болсон ХХ зууны сүүлчээс цаг хугацааны эрхэнд мартагдсан Чингис хаан “Бурхан” ч биш, “Буг” ч биш мянганы алдарт хүн гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн юм. Дэлхий нийтийн чиг хандлагатай уялдан мянганы алдарт төрийн зүтгэлтнийг төрүүлсэн өнөөгийн Монгол орон, монголчууд Чингисээрээ бахархах нь ч зүйн хэрэг боллоо.

Монгол дахь Чингис судлалын эрдэм шинжилгээний ач холбогдол хэзээ хэзээнээс илүү өсч байгааг харгалзан дор дурдсан арга хэмжээг авууштай. Үүнд:

а. Өдгөө Монгол оронд ертөнцийн шинэ соёл өдөр бүр сацран дэлгэрч байгаа тул Орос, хятад, англи, герман, франц, япон хэлийг төгс сайн мэдэж орчуулах ур чадвар сайтай хүмүүсийн бүтэц бүхий Чингис судлалын Хүрээлэнг Монголын ШУА-ийн харьяа төр, засгийн ивээл дор шинээр байгуулах;

б. Дэлхийн олон улс оронд Чингисийн талаар хэвлэгдэн гарсан ном, өгүүлэл, хэрэглэгдэхүүнийг цуглуулж, эх хэлнээ орчуулан Монгол уншигчдын хүртээл болгох, тэдгээрийг харьцуулан Чингис хааны талаарх тулгуур судалгаа хийж, дорвитой бүтээл туурвих;

в. Алтанургийн хүрээний судалгааг зөвхөн Чингис, түүнийг залгамжлагчдаар хязгаарлахгүй хошуу захирч байсан залгамж халаа ноёдын намтар судлалыг хөгжүүлэх;

г. Чингистэй нэр холбогдсон газар нутаг, аман домгийн эрлийг эрчимжүүлж бүтээл туурвих. Дурсгалт цэгүүдэд самбар, бармалууд хийж тавих;

д. Дорнод аймгийн Булган сумын нутагт орших Чингисийн Тугийн сүмийг урьд байснаар нь сэргээж, Өвөр монголын ордос дахь Эзэн хорооноос дутахааргүй тохижуулж, аялал жуулчлалын нэгэн том цогцолбор болгох саналыг дэвшүүлж байна.

Э.Лувсанбалдан
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Богд суут Чингис хааны сан оршив. Гар бичмэл.
2. Суут Богд Чингис хааны цэнгэлийн далай хэмээх Ордос мэргэн ламын зохиол. Гар бичмэл.
3. МАХН-ын ТХ-ны тогтоолууд. Хэвлэлийн тухай (1947-1952). УБ. 1953.
4. Н.Наганбуу. Дэлхийн Чингис хаан. Интернэтэд бий.
5. “Үнэн” сонин. 1949 он. №290 (4366)
6. Монголын нууц товчоо. УБ. 1947.
7. Сургуулийн тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолууд. УБ. 1953.
8. СССР-ийн түүх. Дунд сургуулийн 8-р ангийн сурах бичиг. УБ. 1953.
9. “Үнэн” сонин. 1950 он. № 2 (4382)
10. Чингис хаан монголчуудын үндэсний бахархал. сүр сүлд. УБ. 2002 он.